



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№01

Улаанбаатар хот

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССООС ТОГТООХ НЬ:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар Н.Энхчулууныг томилсугай.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА



Б.НАРАНТУЯА



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН КОМИССООС ТОГТООХ НЬ:

НЭГ. Нийт хувь нийлүүлэгчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 12 135383 ширхэг буюу нийт 76,5 хувь нь хуралд ирж, компанийн дүрмийн 7.4 – т “Хувьцаа эзэмшигчдийн хурал нь саналын эрхтэй нийт хувьцааны 70 – аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцно.” гэж заасны дагуу хурлыг хүчин төгөлдөр гэж үзсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н.ЭНХЧУЛУУН



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№ 03

Улаанбаатар хот

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССООС ТОГТООХ НЬ:

НЭГ. Нийт хувь нийлүүлэгчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 12 135383 ширхэг буюу нийт 76,5/хувь/ - ийн ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсон тул гишүүдийн 100% - ийн саналаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар хувьцаа эзэмшигч Б.Цогтгэрэлийг томилсугай.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА



Б.НАРАНТУЯА



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 27 өдөр

№ 04 Улаанбаатар хот

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж “ХАНГАЛТГҮЙ” ажиллалаа гэж дүгнэсүгэй.

ХОЁР. Шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлд компанийн 2019 оны үйл ажиллагааг сайжруулж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ЦОГТГЭРЭЛ



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№ 05 Улаанбаатар хот

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн 2017 оны санхүүгийн тайланг хэлэлцэж “ХАНГАЛТГҮЙ” гэж дүгнэсүгэй.

ХОЁР. Шинээр томилогдсон Гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлд 2019 онд компанийн санхүүгийн байдлыг дээшлүүлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ЦОГТГЭРЭЛ



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№ 06 Улаанбаатар хот

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн удирдлага, үйл ажиллагааны зардлыг 2019 оны санхүүгийн төсөв төлөвлөгөөнд тусгаснаар баталсугай.

ХОЁР. 2019 оны удирдлага, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ЦОГТГЭРЭЛ



“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26 өдөр

№ 07 Улаанбаатар хот

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

НЭГ. 2018 онд гүйцэтгэсэн барилга угсралтын ажлаараа өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр зээлээ төлж хуримтлал үүсэх боломж бүрдээгүй тул 2019 онд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ЦОГТГЭРЭЛ